

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2026 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 405.

Арвайхээр сум

“Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрөл сунгах, шинээр олгох, нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2,19.3,19.14, 19.15, 19.18, дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 14,15, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн “Тушаал хүчингүй болгох тухай” а/40 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох комиссын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн шийдвэрийг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрөл олгох нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагыг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд хаягийн өөрчлөлт оруулах нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагын нэрсийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргалд)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ОЮУНТУЯА

622331026

Эрүүл мэндийн газрын даргын  
2026 оны 02 дугаар сарын 28-ны  
өдрийн 405 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
НЭР БҮХИЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр, регистрийн дугаар, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл сунгах хугацаа	Хүчинтэй байх огноо
1	“Гантиг ундрэм” ХХК “Саруул гэгээ” нүдний цогц тусламж үйлчилгээ үзүүлэх РД-3576078 1011121807	Үүдэн эмнэлэг	Арвайхээр сум 5-р баг	3 жил	2029.02.28- ний өдрийг хүртэл

---oOo---

Эрүүл мэндийн газрын даргын  
2026 оны 02 дугаар сарын 22-ны  
өдрийн 405 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
НЭР БҮХИЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр, регистрийн дугаар, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Нэмэлт өөрчлөлтийн агуулга
1	“Өвөрхангай эм хангамж” ХХК “Арвижих” эмийн сан РД-2058219 1011001034 ЭХ-13/19/45	Эм эмнэлгийн хэрэгсэл, гоо сайхны худалдаа	Хархорин сум Ганган- Орхон баг	Байршил Арвайхээр сумын 13-р баг Шинэ Арвайхээр, 506-р байр гэснийг Хархорин сум 3-р баг Усжуулах-1 1А тоот Номин агуулах худалдааны төвд байршиж үйлчилгээ явуулах тул хаягийн өөрчлөлт хийв.

---oOo---